

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/12/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Утас: 70272298, Факс: 70272582, И-мэйл: tva@audit.gov.mn

2022.02.21 № 01/34
Тангилт: _____ Үндэслэл: _____

ТӨВ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Э.УЯНГА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020197

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансн	Балансын үзүүлэлт	Эхний	Эцсийн
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,506,650.00	34,049,450.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,545,600.00	12,575,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,545,600.00	12,575,600.00
3121	Төгрөг	6,545,600.00	12,575,600.00
31213	Арилжааны банк дахь харилцах	6,545,600.00	12,575,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,961,050.00	21,473,850.00
354	Хангамжийн материал	10,961,050.00	21,473,850.00
35420	Аж ахуйн материал	2,298,550.00	2,773,000.00
35450	Барилгын засварын материал	2,841,000.00	7,619,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,821,500.00	11,081,850.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	458,946,110.32	550,854,929.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	458,946,110.32	550,854,929.41
392	Биет хөрөнгө	411,108,401.72	503,052,970.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	258,060,510.00	311,104,510.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,560,512.88	-9,452,550.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,128,570.00	143,128,570.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,262,500.34	-81,558,928.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,959,346.36	116,119,503.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,441,635.91	-37,411,655.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,609,396.43	81,607,396.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,133,469.38	-20,747,556.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,275,232.00	7,275,232.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,526,534.56	-7,011,550.08
393	Биет бус хөрөнгө	47,837,708.60	47,801,958.62
39301	Програм хангамж	1,265,000.00	1,265,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,102,291.40	-1,138,041.38
39303	Бусад биет бус хөрөнгө	47,675,000.00	47,675,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	476,452,760.32	584,904,379.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,545,600.00	12,575,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,545,600.00	12,575,600.00
414	Урьдчилж орсон орлого	6,545,600.00	12,575,600.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	6,545,600.00	12,575,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	469,907,160.32	572,328,779.41
51	Засгийн газрын хувь оролцоо	469,907,160.32	572,328,779.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	254,549,065.00	254,549,065.00
51101	Өмч: - төрийн	254,549,065.00	254,549,065.00
512	Хуримтлагдсан үр дүн	54,140,199.96	156,561,819.05
51210	Өмнөх үеийн үр дүн	54,140,199.96	54,140,199.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	102,421,619.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	161,217,895.36	161,217,895.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	476,452,760.32	584,904,379.41

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	816,408,083.41	1,134,610,357.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,743,883.41	99,243,457.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,743,883.41	99,243,457.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,743,883.41	99,243,457.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,743,883.41	99,208,457.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	45,563,883.41	96,229,457.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,180,000.00	2,979,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	768,664,200.00	1,035,366,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	768,664,200.00	1,035,366,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	768,664,200.00	1,035,366,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	795,251,553.52	1,032,188,737.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	795,251,553.52	1,032,188,737.91
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	784,832,927.58	1,031,688,737.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,070,808.03	716,896,502.60
210101	Үндсэн цалин	517,234,396.94	466,404,649.00
210102	Нэмэгдэл	39,633,911.09	219,239,019.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,202,500.00	31,252,834.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,936,697.03	92,110,869.80
210201	Тэтгэврийн даатгал	49,173,864.03	62,614,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,690,708.00	8,105,469.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,552,567.00	5,704,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,138,142.00	1,426,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,381,416.00	14,260,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,709,249.00	32,073,882.00
210301	Гэрэл, цахилгаан	2,580,308.00	2,596,782.00
210302	Түлш, халаалт	25,733,251.00	25,733,250.00
210303	Цэвэр, бохир ус	2,395,690.00	3,743,850.00
2104	Хангамж бараа материалын зардал	36,211,653.00	27,819,284.00
210401	Бичиг хэрэг	10,649,740.00	10,957,350.00
210402	Тээвэр, шатахуун	10,660,000.00	10,000,065.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,296,840.00	3,629,499.00
210404	Ном, хэвлэл	102,200.00	406,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,449,950.00	1,002,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,052,923.00	1,824,320.00
2105	Нормативт зардал	64,610.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	64,610.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,121,890.00	57,737,202.00
210604	Урсгал засвар	37,121,890.00	57,737,202.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	7,956,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	7,956,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,431,445.00	28,079,398.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,920,000.00	25,686,893.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,175.00	1,206,855.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,270.00	234,098.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	313,500.00
210807	Газрын төлбөр	324,000.00	140,052.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,486,575.52	69,015,599.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,771,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,550,000.00	12,600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,436,575.52	31,293,337.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,418,625.94	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,850,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,850,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,568,625.94	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,568,625.94	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,156,529.89	102,421,619.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,156,529.89	102,421,619.09

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	32,983,670.07	00.00	448,750,630.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	32,983,670.07	00.00	448,750,630.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,156,529.89	00.00	21,156,529.89
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	54,140,199.96	00.00	469,907,160.32
D01	2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	54,140,199.96	00.00	469,907,160.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	54,140,199.96	00.00	469,907,160.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	102,421,619.09	00.00	102,421,619.09
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	156,561,819.05	00.00	572,328,779.41

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	772,664,200.00	1,041,396,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	772,664,200.00	1,041,396,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	768,664,200.00	1,035,366,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	768,664,200.00	1,035,366,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,000,000.00	6,030,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,000,000.00	6,030,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	761,593,200.00	1,008,394,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	761,593,200.00	1,008,394,200.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	751,174,574.06	1,007,894,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,070,808.03	717,871,572.40
210101	Үндсэн цалин	517,234,396.94	464,987,118.80
210102	Нэмэгдэл	39,633,911.09	221,631,619.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,202,500.00	31,252,834.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,936,697.03	91,135,800.00
210201	Тэтгэврийн даатгал	67,524,558.19	62,614,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,142,941.56	7,130,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	894,193.21	5,704,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	215,909.46	1,426,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,159,094.61	14,260,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,709,249.00	32,073,882.00
210301	Гэрэл, цахилгаан	2,580,308.00	2,596,782.00
210302	Түлш, халаалт	25,733,251.00	25,733,250.00
210303	Цэвэр, бохир ус	2,395,690.00	3,743,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,781,760.00	30,755,029.00
210401	Бичиг хэрэг	10,649,740.00	10,922,350.00
210402	Тээвэр, шатахуун	10,660,000.00	9,999,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,296,840.00	3,629,499.00
210404	Ном, хэвлэл	102,200.00	406,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,050,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,022,980.00	4,797,220.00
2105	Нормативт зардал	63,725.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	63,725.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,530,890.00	63,073,652.00
210601	Багаж техник, хэрэгсэл	229,000.00	00.00
210604	Урсгал засвар	27,301,890.00	63,073,652.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	7,956,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	7,956,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,231,445.00	25,279,503.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,720,000.00	22,886,998.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,175.00	1,206,855.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,270.00	234,098.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	313,500.00
210807	Газрын төлбөр	324,000.00	140,052.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,050,000.00	39,748,761.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	4,798,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,550,000.00	12,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,418,625.94	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,850,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,568,625.94	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,568,625.94	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,071,000.00	33,002,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,071,000.00	26,972,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,071,000.00	26,972,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,071,000.00	26,972,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,071,000.00	26,972,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,071,000.00	-26,972,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,000,000.00	6,030,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,545,600.00	6,545,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,545,600.00	12,575,600.00

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт хэмнэлт
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	768,664,200.0	768,664,200.0	1,035,366,900.0	1,035,366,900.0	00.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,664,200.0	768,664,200.0	1,035,366,900.0	1,035,366,900.0	00.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,614,200.0	766,246,674.1	1,034,986,900.0	1,012,616,188.4	22,360,711.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,777,700.0	669,070,808.0	729,086,400.0	717,871,672.4	11,214,827.6
210101	Үндсэн цалин	415,080,900.0	517,234,396.9	464,968,000.0	464,967,118.8	881.2
210102	Нэмэгдэл	144,047,600.0	39,633,911.1	229,599,200.0	221,631,619.6	7,967,580.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,649,200.0	12,202,500.0	34,499,200.0	31,252,834.0	3,246,366.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шийтгэл	72,341,900.0	71,936,697.0	91,135,800.0	91,135,800.0	00.0
210201	Тэтгэрийн даатгал	49,222,300.0	67,524,558.2	62,614,000.0	62,614,000.0	00.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,779,900.0	1,142,941.6	7,130,400.0	7,130,400.0	00.0
210203	ҮОМШЭ-ний даатгал	4,623,900.0	894,193.2	5,704,400.0	5,704,400.0	00.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,156,000.0	215,909.5	1,426,100.0	1,426,100.0	00.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,559,800.0	2,159,094.6	14,260,900.0	14,260,900.0	00.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,794,000.0	30,709,249.0	38,463,800.0	32,073,882.0	6,379,918.0
210301	Гэрэл, цахилгаан	3,823,100.0	2,580,308.0	4,820,400.0	2,596,782.0	2,223,618.0
210302	Тулш халаалт	26,095,700.0	25,733,251.0	26,965,000.0	25,733,250.0	1,231,750.0
210303	Цэвэр, бохир ус	875,200.0	2,395,690.0	6,668,400.0	3,743,850.0	2,924,550.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,100,000.0	28,781,780.0	33,809,800.0	30,766,029.0	3,064,771.0
210401	Бичиг хэрэг	10,660,000.0	10,649,740.0	10,987,500.0	10,922,350.0	65,150.0
210402	Тээвэр, шатахуун	10,660,000.0	10,660,000.0	10,000,000.0	9,999,960.0	40.0
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	4,347,000.0	4,296,840.0	6,613,100.0	3,629,499.0	2,983,601.0
210404	Ном, хэвлэл	200,000.0	102,200.0	409,200.0	406,000.0	3,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,090,000.0	2,050,000.0	1,000,000.0	1,000,000.0	00.0
210406	Бага үнэтэй, түргэн эзэгдэх, эхийн эд зүйлс	1,153,000.0	1,022,980.0	4,800,000.0	4,797,220.0	2,780.0
2106	Нормативт зардал	66,000.0	63,725.0	00.0	00.0	00.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.0	63,725.0	00.0	00.0	00.0
2106	Эд хөвшил, урсгал засварын зардал	34,603,200.0	34,601,890.0	80,084,100.0	80,046,382.0	37,748.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,300,000.0	7,300,000.0	9,000,000.0	8,974,700.0	25,300.0
210602	Тавигта	00.0	00.0	18,000,000.0	17,998,000.0	2,000.0
210604	Урсгал засвар	27,303,200.0	27,301,890.0	63,084,100.0	63,073,682.0	10,448.0
2107	Томилголт, зочны зардал	1,800,000.0	1,800,000.0	8,464,000.0	7,966,000.0	1,498,000.0
210702	Дотоод албан томилолт	1,800,000.0	1,800,000.0	9,454,000.0	7,956,000.0	1,498,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,282,400.0	10,231,446.0	25,443,000.0	26,279,603.0	163,487.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	8,770,000.0	8,720,000.0	22,887,000.0	22,886,998.0	02.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.0	00.0	432,000.0	432,000.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	961,200.0	961,175.0	1,370,300.0	1,206,855.0	163,445.0
210804	Тээврийн хэрэгслийн татавар	227,200.0	226,270.0	234,100.0	234,098.0	02.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.0	00.0	66,000.0	66,000.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.0	00.0	313,500.0	313,500.0	00.0
210807	Газрын төлбөр	324,000.0	324,000.0	140,100.0	140,052.0	48.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,060,000.0	11,060,000.0	17,400,000.0	17,398,060.0	1,860.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.0	2,500,000.0	4,800,000.0	4,798,050.0	1,950.0
210902	Хинээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,560,000.0	8,560,000.0	12,600,000.0	12,600,000.0	00.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,860,000.0	1,860,000.0	600,000.0	600,000.0	00.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,860,000.0	1,860,000.0	600,000.0	600,000.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шалгал урамшлал	1,860,000.0	1,860,000.0	500,000.0	500,000.0	00.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	768,664,200.0	768,664,200.0	1,035,366,900.0	1,035,366,900.0	00.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	768,664,200.0	768,664,200.0	1,035,366,900.0	1,035,366,900.0	00.0
131001	Улсын төсвөөс санхүүжлэх	768,664,200.0	768,664,200.0	1,035,366,900.0	1,035,366,900.0	00.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	2,646,600.0	00.0	6,646,600.0	-6,646,600.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	6,646,600.0	00.0	12,676,600.0	-12,676,600.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.0	01.0	01.0	01.0	00.0
610001	Төсвийн байгууллага	01.0	01.0	01.0	01.0	00.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31.0	30.0	31.0	30.0	01.0
620001	Удирдах ажилтан	01.0	01.0	01.0	01.0	00.0
620002	Гүйцэтгэх ажилтан	20.0	19.0	19.0	18.0	01.0
620003	Үйлчлэх ажилтан	10.0	10.0	11.0	11.0	00.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 1/205 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Прокурорын газар нь прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж тодорхой үр дүнд хүрч ажиллах, прокурор ажилчдын нийгмийн асуудал, эрүүл мэндийн байдлыг сайжруулах, хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургаж чадавхжуулах бодлого явуулах, тодорхой ажлуудыг хийж тайлагнах хэрэгжүүлэх төрийн тусгай алба юм.

Төв аймгийн Прокурорын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Прокурорын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Прокурорын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын ерөнхий прокурорын газрын Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг, дотоод аудитор ажилладаг бөгөөд журам зааврыг хуулийн хүрээнд боловсруулж батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу хяналт шалгалтыг явуулдаг байна. Тус байгууллагад Улсын ерөнхий прокурорын газрын Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хэлтсээс 2021 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй тул дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Прокурорын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 816.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Прокурорын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 17.0 сая төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 4.8 сая төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 12.8 сая төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Прокурорын байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 1,035.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 99.2 сая төгрөг нийт 1,134.6 сая төгрөг өмнөх оноос 318.2 сая төгрөгөөр буюу 38.97 хувиар өссөн байна.

Зардал :

Төв аймгийн Прокурорын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,032.2 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,008.4 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,035.4 сая төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140006001 тоот дансанд 2021 онд 1,039.9 сая төгрөгийн орлого, 1,039.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Тус байгууллага төрийн сан дахь эрүүгийн хэргийн барьцаа 100140006350 тоот данс оны эхэнд 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлант онд 6.0 сая төгрөг нэмэгдэж 12.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6.5	12.5	-6.0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	11.0	21.5	-10.5
Үндсэн хөрөнгө	458.9	550.9	-92.0
Нийт хөрөнгө	476.4	584.9	-108.5
Өр төлбөр	6.5	12.6	-6.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	469.9	572.3	-102.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	476.4	584.9	-108.5

Бараа материалын дансны үлдэгдэл 21.5 сая төгрөг болж 10.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 550.9 сая төгрөг болж 92.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 27.0 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 96.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 572.3 сая төгрөг болж 102.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,046.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,046.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 157.0 сая төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 889.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь конторын барилгын өргөтгөл барих зардлыг бууруулсантай холбоотой байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/01 тоот тушаалаар 2021 онд зарцуулах төсвийн хуваарийг 889.6 сая төгрөгөөр ирүүлснийг 2021 оны 02 дугаар сард 911.3 сая төгрөг, 5 дугаар сард 960.2 сая төгрөг, 8 дугаар сард 978.3 сая төгрөг болгон төсвийн урсгал зардлын хуваарьт өөрчлөлт оруулж, Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд тодотгол хийсэнтэй холбоотойгоор Прокурорын байгууллагын 2021 оны төсвийн урсгал зардлыг тодотгон баталснаар Төв аймгийн Прокурорын газрын төсвийн урсгал зардлыг 12 дугаар сард 1,035.4 сая төгрөгөөр тодотгон ирүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,035.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1,035.4 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,035.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,013.0 сая төгрөгийг зарцуулж, 22.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,013.0 сая төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь 22.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Прокурорын газар тайлант онд эрүүгийн хэргийн барьцаа дансанд 6.0 төгрөгийн орлого бүрдүүлж, зарцуулаагүй 12.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Прокурорын газар улсын төсвийн хөрөнгөөр 9.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 18.0 сая төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авсан, Улсын Прокурорын ерөнхий газраас 53.0 сая төгрөгийн орон сууц, 41.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2.0

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

сая төгрөгийн тавилга хэрэгсэл, 3.0 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авч санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Төв аймгийн Прокурорын газрын конторын дээврийн засварт 39.9 сая төгрөг, гражийн дээвэр, сантехникийн засварт 7.9 сая төгрөг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны прокурор, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт үе шаттайгаар хамруулж, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөрт Зермат монголие ХХК-д 12.4 сая төгрөг, албан хаагчдыг англи хэлний анхан, дунд шатны сургалтад хамруулахаар Тэмүүлэл сургалтын холбоо сургалтын төвд 12.0 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12, зарлагын 17 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 10 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Прокурорын газар нь эрүүгийн хэргийн барьцаа дансанд төвлөрүүлсэн 6.0 сая төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх, е-баримтын худалдан авалт, арвилан хэмнэлт үр ашиг, улсын төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой 4 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Прокурорын газрын тамгын хэлтсийн даргын 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 1/599 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ахмадын сангийн дансанд төвлөрүүлж байгаа зардлыг дараагийн аудитаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 100.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27.0 сая төгрөгийн алдааг залруулж, 73.2 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

4.2.1 Залруулсан алдаа

Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 27.0 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгийн зардалд тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан Бодох Бүртгэлийн тухай Хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан Бодох Бүртгэлийн тухай Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/173 тоот тушаал ирүүлсний дагуу УПЕГ-Ахмадын сан төрийн банкин дах 100100084150 тоот дансанд 21.9 сая төгрөгийг үндсэн цалин, нэмэгдэл цалингийн зардлаас улсын төсөвт төвлөрүүлэхгүйгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төв аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

- Ахмадын санд төсвөөс мөнгө зарцуулж санхүүжүүлэхгүй байх, холбогдох хууль тогтоомж мөрдөж ажиллах.

1.3 Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд ажилчдын эрүүл мэндийн үзлэгт 12.3 сая төгрөг, англи хэлний сургалтад 12.0 сая төгрөг, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авахад 27.0 сая төгрөг нийт 51.3 сая төгрөгийн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

1.4 Өгсөн зөвлөмж

- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Прокурорын газар	3	100.2	1	27.0	0	0	0	0	2	73.2

